

<https://doi.org/10.69561/mjac.v25i49.3839>

Review article | Fasc.14

Өвөр монголын найрал дууны бүлгэмийн хувьсал, хөгжлийн үйл явц

Мэдээгийн Мандлаа 

Соёл урлагийн их сургуулийн Хөгжмийн урлагийн сургууль,
Улаанбаатар, Монгол Улс

Данзангийн Энхцэцэг 

Соёл урлагийн их сургуулийн Хөгжмийн урлагийн сургууль,
Улаанбаатар, Монгол Улс

✉ enkhee.art1010@gmail.com

Хураангуй: Энэхүү өгүүлэлдээ БНХАУ-ын Өвөр монголын найрал дууны бүлгэмийн үүсэл хөгжлийг 1987 онд байгуулагдсан “Монгол үндэстний залуучуудын найрал дууны бүлгэм”-ийн уран бүтээлийн үйл ажиллагаатай холбон авч үзсэн болно. Учир нь найрал дууны урлаг Өвөр монгол оронд үүсэж хөгжихдөө чухамхүү тухайн цаг үе, нийгэм соёл, төр засгийн бодлогын дагуу явагдаж, тухайлбал, 1945 онд БНХАУ-д Өвөр монголыг чөлөөлөх хөдөлгөөн өрнүүлэхээр төлөвлөн, 1946 оны 04-р сарын 01-ний өдөр “Утга урлагийн бүлгэм” байгуулан, намын бодлогыг ард түмэнд хүргэх зорилго бүхий суртал ухуулгын чиглэлээр найрал дууны урлагийн эх үүсвэр тавигдсан байдаг. Энэ үйл явцын үр дүнд Өвөр монголд найрал дууны олон арван бүлгэм ажиллаж иржээ. Харин 1987 онд байгуулагдсан “Монгол үндэстний залуучуудын найрал дууны бүлгэм”-ийн хувьд хөгжлийн шинэ шатанд гарсан хэмээн үзэж байгаа болно.

Түлхүүр үгс: найрал дууны бүлгэм, уламжлал, шинэчлэл, найрал дууны урлаг

The Evolution and Development process of the choir team /group/ of Inner Mongolian

Mandlaa Medee 

School of Music Arts, Mongolian National University of Arts and Culture,
Ulaanbaatar, Mongolia

Enkhtsetseg Danzan 

School of Music Arts, Mongolian National University of Arts and Culture,
Ulaanbaatar, Mongolia

✉ enkhee.art1010@gmail.com

Abstract: This article examines the development of the Inner Mongolian choral art in China in relation to the creative activities of the “Mongolian National Youth Choir” established in 1987. Because the development of choral art in Inner Mongolia was carried



out in accordance with the time, society, culture, and government policies of that time. For example, in 1945, the “Literature and Art Group” was established in China on April 1, 1946, with the aim of launching a movement to liberate Inner Mongolia. In this way, the source of choral art was laid in the field of propaganda with the aim of conveying the party’s policies to the people. As a result of this process, dozens of choral groups have been operating in Inner Mongolia. However, the “Mongolian National Youth Choir” established in 1987 is considered to have entered a new stage of development.

Keywords: *choir, tradition, innovation, choral art*

Оршил

Энэхүү өгүүлэлд Өвөр монгол дахь найрал дууны урлаг хэрхэн үүсэж хөгжиж ирсэн, хувьсан өөрчлөгдсөн талаарх түүхэн байдлыг тодруулан гаргах, ингэхдээ уг урлагийн гарамгай төлөөлөл болох уран бүтээлчдийн судалгааг хийсэн болно. Урьд өмнөх судалгаануудад энэ асуудлыг хөндөн гаргаж байсан хэдий ч бүх цаг үеийг хамарсан тойм судалгаа хийгдээгүй юм. Энэ нь Өвөр монгол оронд нутагшсан хөгжмийн урлагийн нэгэн томоохон төрлийг авч үзсэнээр найрал дууны урлагийн хөгжил дэх нийгэм соёлын орчин, төр засгийн урлаг соёлын бодлогын хэрэгжилт, үүнийгээ дагасан урын сангийн төрөл, хэлбэр, уран бүтээлчдийн бүтээн туурвих арга барил зэрэг асуудлыг эрхгүй хөндөж байгаа болно.

Судалгааны арга зүй

Энэхүү өгүүлийг бичихдээ ярилцлагын болон баримтжуулах арга, мөн түүхэн зүйн аргыг хэрэглэсэн болно.

Судалгааны үр дүн

БНХАУ-ын ӨМӨЗО-ны найрал дууны урлаг, тэр дундаа монгол найрал дууны хамтлагуудын үүсэл, хөгжлийн үйл явцын тухайн цаг үеийн тэргүүлэх уран бүтээлчдийн хамтаар судлан тодруулснаар бүс нутгийн хөгжмийн урлагийн хувьсал, хөгжлийн үйл явцыг бүрэн хэлбэрээр тодорхойлон гаргах, улмаар анх удаа Өвөр монголын найрал дууны урлагийн дагнасан судалгааны эхийг тавих боломжийг бүрдүүлж байгаагаараа үр дүнтэй.

XVIII зууны тэргүүн хагасын монголын дуун урлахуй ухааны томоохон төлөөлөгч, уран сэтгэгч “Чин сүжигт Номун хан” өргөмжлөлт Лувсанноровшарав гэгээнтэн нь нутгийнхаа Галуутын хийд, Ордосын “Шар зуу” хэмээх сүм хийдийг байгуулалцан, гүн ухаан, анагаах ухаан, тэжээх ухаан, зурхай, дуу хөгжмийн дацан хэмээгээд, түүндээ “дөчин дуут” гэсэн найрал дууны бүлгэм байгуулсан түүхтэй ажээ. Тэрээр “унзад дуутай арван хүн, үхрээ дуутай арван хүн, ухаа дуутай арван хүн, нарийн буюу хүүхэд дуутай арван хүн”-ийг оролцуулан олон хоолойн найрал дууны чуулга байгуулж, сайн суралцсан ахуйд “Дөчин дуут” хэмээх цол олгож байсан бөгөөд найрал дууны урлагийн дэг сургуулийг үндэслэн, өрнийн хэв маягийн дан найрал дуу (акапелла) буюу шашин сүм хийдийн мөргөлийн “магтуу” дууны төрөл (кантата) хөгжих эхлэлийг тавьжээ гэсэн тэмдэглэл байдаг (Эрдэнэчимэг 2015).

Харин Өвөр монголын орчин цагийн мэргэжлийн найрал дууны урлагийн эх үүслийг 1940-өөд оноос авч үзэж болох юм. Учир нь энэ цаг үеэс БНХАУ-ын хөгжмийн мэргэжилтнүүд ӨМӨЗО-д ирж анхны бүлгэм байгуулах үйл ажиллагаанд оролцож байх үед “Хатан голын их найрал дуу”, “Манай ажилчид чадал дорвитой”, “Нэхмэлчин хүүхэн” зэрэг найрал дууг хятад хэлээр дуулж байсан бол 1947 оны Өвөр монгол чөлөөлөгдөх ёслол болон 1949 онд БНХАУ байгуулагдсаны дараах оны улсын баярын Бээжин хотноо болсон тоглолт дээр хөгжмийн зохиолч Мэлчигийн “Эв хамт намаа үүрд дагана”, Ша Чингийн (Хятад үндэстэн) “Монгол хятадын бүлгэмдлийн дуу” зэрэг дууг дуулж байсан тэмдэглэл бий. Энэ баримтад тулгуурлан “Эв хамт намаа үүрд дагана” найрал дууг өвөр монголын өөрийн орны хөгжмийн зохиолчийн анхны бүтээл хэмээн үзэж байгаа юм (Мэлчиг 2006). Тухайн үед дууны дугуйлан гэж нэрлэж байсан бөгөөд найрал дуу дуулах хүмүүс цөөн байсан учраас бүлгэмийн бүжигчид, хөгжимчдөөс сонгон авч найрал дуунд дуулуулж байсан тухай Мэлчиг өгүүлэлдээ дурдсан нь тэр цаг үед найрал дуунд дуулж байсан бүжигчин Д.Цэцэнтархи багштай уулзан сурвалжлахад энэ тухай ярьсантай утга нэг болж байна. Дууны дугуйлан ийнхүү гараагаа эхэлж хөгжсөөр өдгөө өвөр монголын дуу бүжиг жүжгийн хүрээлэн болж дотроо найрал дууны бүлгэм салбарлан үйл ажиллагаа өрнүүлж байна.

Найрал дуутай холбоотой дараагийн бүлгэм бол “Радио телевизийн утга урлагийн бүлгэм” юм. 1957 онд Радио телевиз хорооны утга урлагийн нэвтрүүлгийн хэрэгцээ шаардлагаас “Өвөр монголын Радио нэвтрүүлгийн дууны дугуйлан” жинхэнээр байгуулагдаж, Сүн Лиан, Чулуу, Дорж зэрэг 8 хүний бүрэлдэхүүнтэйгээр гол төлөв ардын дуу, үлгэр, ардын хөгжим зэргийг нэвтрүүлж байжээ. 1958 онд энэхүү дууны дугуйлангаа өргөтгөж, 16 хүний бүрэлдэхүүнтэй болж, “Өвөр монголын Радио нэвтрүүлгийн дууны бүлгэм” нэртэйгээр, 1960 онд монгол утга урлагийн программын хөгжилтийг дагалдан дууны бүлгэмийн суурин дээр өргөжүүлэн “Өвөр Монголын Радио нэвтрүүлгийн туршилтын утга урлагийн бүлгэм” гэж 60 хүний бүрэлдэхүүнтэйгээр тус тус байгуулжээ. Харин 1966 онд соёлын хувьсгал гарснаар тэрээр үйл ажиллагаа нь зогсонги байдалд орсон бөгөөд 1971 оноос дахин сэргээснээр 1983 онд “Өвөр монголын Радио телевизийн уран сайхны бүлгэм” нэртэйгээр 80 хүний бүрэлдэхүүнтэй болж өргөжсөн байна.

Ийнхүү 1957 оны Өвөр монголын Радио нэвтрүүлгийн анхны дууны дугуйлангаас 20 гаруй жилийн хугацаанд мэргэжлийн урлагийн бүлгэм болтлоо хөгжиж, Монгол, Хятад, Дагуур, Хотон, Манж, Төвд, Солонгос, Ши Бө зэрэг найман үндэстний дуучдаас бүрэлдсэн томоохон бүлгэм болж, найрал дууны удирдаач Ц.Ялуунгэрэл нар удирдаачаар ажиллаж, Ө.Юнрэв, С.Алтан-Уул, Ван Рүй Лин, О.Улаантуг зэрэг хөгжмийн зохиолчдын бүтээлийг олон түмэнд таниулж, үндэсний урлаг соёлыг хөгжүүлэхэд ихээхэн хувь нэмэр оруулсан юм.

Өвөр монголын найрал дууны тоглолт нь голдуу баяр ёслолын үеэр бэлгэдлийн шинжтэй, ихэнхдээ хөгжмийн хамсраатай олуул дуулж байсан бол хожим нь дан найрал дууны төрлөөр голлон туурвиж, 1991-2013 оны хугацаанд Хятад улс төдийгүй, олон улсын уралдаан тэмцээнд амжилттай оролцож байв.

Өвөр монголын найрал дууны урлагийн хөгжил дэх онцолж дурдах нэгэн бүлгэм бол 1987 онд байгуулагдсан “Өвөр монголын монгол үндэстний

залуучуудын найрал дууны бүлгэм” юм. Энэ бүлгэмийн гэрчилгээ болон найрал дуучдын зургийг бид илтгэлдээ хавсаргаж байгааг *Зураг 1, 2*-оос харна уу.



Зураг 1. Монгол үндэстний залуучуудын найрал дууны бүлгэмийн гэрчилгээ



Зураг 2. Монгол үндэстний залуучуудын найрал дууны бүлгэмийн хамт олон

1987 онд Өвөр монголын залуучуудын эвлэлийн харьяалалд Г.Хүрэл, Ц.Ялуунгэрэл, С.Энхбаяр нарын санаачилгаар “Өвөр монголын Монгол үндэстний залуучуудын найрал дууны бүлгэм” байгуулагдсанаар найрал дууны урлагийн хөгжил бас нэгэн шинэ шатанд гарч хөгжих гараа эхэлсэн бөгөөд энэ үеийг эргэлтийн түүхэн үе хэмээн үзэж болох юм. Учир нь чухам энэ л үеэс ӨМӨЗО-ы найрал дууны урлаг мэргэжлийн түвшинд системтэй хөгжиж эхэлсэн юм.

1991-2008 оны хооронд энэ бүлгэмийн үйл ажиллагаа маш эрчимтэй хөгжиж, мэргэжлийн найрал дууны удирдаачийн нөлөөн дор тоглолтын уран сайхны соёлын түвшин эрс дээшилж, БНХАУ төдийгүй гадаад оронд зохиогдох уралдаан тэмцээнүүдэд амжилттай оролцож иржээ.

“Өвөр монголын Монгол үндэстний залуучуудын найрал дууны бүлгэм” нь анх байгуулагдахдаа эхлээд дуучид бүрээс хоёр юань хураан ноот цаасны хэрэглээгээ хангаж байсан бол олон улсын уралдаанд байр эзэлж амжилт үзүүлснээр өвөр монголын Засгийн ордноос тэтгэлгийн мөнгө хуваарилан шууд дэмжлэг үзүүлж эхэлсэн нь уг бүлгэмийн хөгжил дэвшилд томоохон нөлөөг үзүүлсэн нь дамжиггүй билээ.

Энэхүү монгол үндэстний залуучуудын найрал дууны бүлгэмийн үйл ажиллагаанд үнэтэй хувь нэмрээ оруулсан хүмүүсийн нэг бол Г.Хүрэл юм. Тэрээр Өвөр монголын Радио телевизийн өндөр дэсийн найруулагч бөгөөд “Өвөр монголын Монгол үндэстний залуучуудын найрал дууны бүлгэм”-ийн албан ёсны төлөөлөгчөөр ажиллаж, хөгжил дэвшилд хамаарал бүхий олон асуудлыг биечлэн гүйцэтгэж байжээ. Тухайлбал, бүлгэмийн улс нийгмийн холбоо хамаарлын асуудал, дотоод гадаадын тоглолт, санхүүжилт, дуун болон дүрс шингээлт, уралдаан тэмцээн зэрэг зохион байгуулалтын олон арван асуудлыг зохицуулан продюсерын түвшинд ажилласан хэмээн үзэж болно.

Мөн найрал дууны бүлгэмийн хөгжлийн үйл явцад ахмад хөгжмийн зохиолчид чин сэтгэлийн дэмжлэг үзүүлж, улмаар хятад, Өвөр монголын хөгжмийн зохиолчдын бүтээлээр голлох урын сангаа бүрдүүлж ирсэн байна. Ингэхдээ дуучдын ур чадварт ихээхэн анхаарч, Радио телевизийн уран сайхны бүлгэм, Өвөр

монголын Дуу бүжгийн бүлгэмийн дуучид, их дээд сургуулийн дуу хөгжмийн багш нар гол бүрэлдэхүүн нь болж байжээ.

Ийнхүү уг бүлгэмийн дуучдын уран чадвар дээшлэхийн хэрээр уран бүтээлийн чанар чансаа сайжирч, Өвөр монгол орны уран сайхны соёлын хөгжилд илтэд давамгайлсан нөлөө бүхий урлагийн төрөл болтлоо хөгжжээ.

Өвөр монголын төдийгүй, бүх Хятадын найрал дууны урлагийн хөгжилд нөлөөлөхүйц нэрд гарсан тухайн бүлгэмийн авьяаслаг хамт олныг бүрдүүлэх нөр их хөдөлмөрийг “Өвөр монголын Монгол үндэстний залуучуудын найрал дууны бүлгэм”-ийн тэргүүлэх уран бүтээлчидтэй шууд холбон авч үзэхээс өөр аргагүй билээ. Энд юуны өмнө найрал дууны удирдаач, багш Ц.Ялуунгэрэлийг онцлох хэрэгтэй бөгөөд мөн хөгжмийн зохиолч Ф.Мэргэжих, Шин Хүү Гуан, Ө.Юнрэв, С.Алтан-Уул, С.Энхбаяр нар энэ бүлгэмийн урын санд зориулан уран бүтээлээ туурвиж байв. Гэсэн хэдий ч найрал дууны бүлгэмийн зохион байгуулалтын үйл ажиллагаа төвөгтэй болсноос дуучид нь өөр өөрийн бүлгэмдээ буцаж, найрал дууны үйл ажиллагаа нь албан байгууллагадаа буюу Радио телевизийн уран сайхны бүлгэм ба Өвөр монголын Дуу бүжгийн бүлгэмд харьяалагдаж цаашид үйл ажиллагаагаа үргэлжлүүлж байв.

2014 онд Радио телевизийн уран сайхны бүлгэмийг төр засгийн шийдвэрээр татан буулгаж, Өвөр монголын Дуу бүжгийн бүлгэмтэй нийлүүлэх шийдвэр гарснаар “Өвөр монголын Дуу бүжиг жүжгийн хүрээлэнгийн найрал дууны бүлгэм” нэртэйгээр одоог хүртэл ажиллаж байна.

Ийнхүү 70 гаруй жилийн хөгжлийн явцдаа өвөр монголын найрал дууны урлаг нь мэргэжлийн найрал дууны цар хүрээнд монгол хэв шинжит өвөрмөц онцлог бүхий урлагийн хэлбэрээр дэлхийн урлагийн тайзнаа гарч, бусад улс үндэстэнд түгэн тархсан уран сайхны соёлын илэрхийллийн чухал нэг үзүүлэлт болжээ.

Дээр дурдсан найрал дууны бүлгэмийн амжилт бүтээлээс цухас дурдвал:

- 1991 онд Бээжингийн гурав дахь удаагийн олон улсын найрал дууны уралдаанд Өвөр монголын Монгол үндэстний залуучуудын найрал дууны бүлгэм “Найман шарга” зохиолоор алтан медаль хүртсэн бол, 1996 онд “Зэрэглээт говь” зохиол нь дэлхийн залуучуудын найрал дууны наадмын заавал дуулах бүтээлээр шалгарсан байна.
- 1998 онд С.Энхбаярын “Өнчин цагаан ботго” найрал дууны бүтээлээр Хятадын Харбин хотод болсон бүх улсын найрал дууны уралдаанд алтан медаль хүртжээ. 1980 онд С.Алтан-Уулын “Үзэсгэлэнт сайхан миний нутаг” дуу нь Юнескогоос дэмжигдэн олон улсад ази номхон далайн орны сургалтын материалд сонгогдон тэмдэглэгджээ. Улмаар 2004 онд “Найман шарга” зохиол нь олон улсын сонгодог бүтээлийн тэмдэглэлд бүртгэгдсэн байна.

2000 онд Австри улсад зохиогдсон олон улсын анхны “Олимпик” найрал дууны уралдаанд Өвөр монголын Монгол үндэстний залуучуудын найрал дууны бүлгэм нь “Монгол гутал”, “Тэмээн жингийн хонх”, “Тойг”, “Найман шарга” зэрэг бүтээлүүдээр уралдааны гурван төрлөөр алтан медаль, 2002 онд Солонгосын Пусон хотод болсон олон улсын найрал дууны уралдаанд Өвөр монголын Радио телевизийн найрал дууны бүлгэмийн дуулсан “Талын дуун”, “Монгол шатар”,

“Өнчин цагаан ботго” зэрэг бүтээлүүд нь тус тус алтан медаль хүртсэн ажээ. Мөн 2007 онд Францад болсон олон улсын найрал дууны тэмцээнд “Талын дуун”, “Динхэржав” зохиолоор уламжлалт хөгжмийн тэргүүн шагнал хүртэж, 2013 онд болсон Австрийн Граз хотноо болсон найрал дууны уралдаанд “Ойрад биелгээ”, “Тойг” зохиолоор алтан медаль хүртсэн гээд олон арван амжилтыг үзүүлжээ.

“Найман шарга”, “Мүү гээ” (“Үхэрт хүйтэн хоёр” уртын дуу), “Дөрвөн далай”, “Зэрэглээт говь” зэрэг монгол онцлогт дан найрал дуунд зориулсан бүтээлүүд гадаадын найрал дууны бүлгэмд төдийгүй, ялангуяа хятадад түгэн тархаж дуулагдах болжээ. Ерөөс монгол найрал дууны бүтээлүүд нь монгол үг хэл, яруу найраг монгол аялга, монгол сэтгэлгээ, монгол хөгжмийн эс элемент зэргийг агуулж байгаа цогц хэлбэр юм. Өвөр монголын дан найрал дууны урлаг нь өрнө дахины найрал дууны найруулгын арга барил, дуулах арга зүй, хоолойн зохицол зэргийг авч хэрэглэсэн боловч түүний хамгийн үндсэн шинж төлөв нь Монгол үндэстний уламжлалт урлагийн элементүүд болон хөгжмийн сэтгэлгээ шингэсэн байдагт оршино.

Өвөр монголын найрал дууны урлагийн хөгжлийн бас нэгэн шинэ үе шат 2008 онд эхэлсэн юм. Учир нь найрал дууны удирдаач Ц.Ялуунгэрэл, хөгжмийн зохиолч С.Энхбаяр нарын санаачилга, оролцоотойгоор Өвөр монголын найрал дууны суурь анги буюу “Өвөр монголын багачуудын найрал дууны бүлгэм” нэртэйгээр, нам засгийн ивээл дор Засгийн газрын тэтгэлгээр 2008 оны 9 сард байгуулагдав. Энэ нь өвөр монголын түүхэн дэх анхны багачуудын найрал дууны бүлгэм болж, бүлгэмийн хүүхдүүдийг орон нутгаас авьяас чадвараар нь шалгаруулан сонгон авч, хөгжмийн онолын суурь хичээлийг Монгол Улсаас ирсэн мэргэшсэн багш нараар заалгаж, хөгжмийн суурь боловсролын чанарт анхаарч байв. Сурагчдын олонх нь Өвөр монгол орны малчин тариачны хүүхдүүд бөгөөд орон даяар сонгож авсан болохоор ихэнх нь авьяаслаг байж, өвөр монголын найрал дуу, хятад найрал дуу, гадаадын бүтээлийг дуулах хэдэн жилийн сургалтаар дамжин төгөлдөр хуур, хийл, морин хуур, шанз, ятга зэрэг олон төрлийн хөгжмийн зэмсгийг сурагчид дур сонирхлын дагуу эзэмшихийн зэрэгцээ мөн монгол бүжгийн мэргэжлийг ч тодорхой түвшинд эзэмшиж байв.

“Өвөр монголын багачуудын найрал дууны бүлгэм”-ийн уран сайхны удирдагчаар найрал дууны тэргүүлэх удирдаач Ц.Ялуунгэрэл амжилттай ажилласнаар энэхүү бүлгэм нь улсын дотоод гадаад уралдаан тэмцээнд удаа дараа амжилт гаргаж, мөн найрал дууны бие даасан аялан тоглолтыг олноор хийсэн болно.

“Өвөр монголын багачуудын найрал дууны бүлгэм”-ийн гаргасан амжилтаас нэгтгэн дурдвал,

- **2012 он:** Хятадын олон улсын найрал дууны XI наадамд багачуудын дугуйлангийн I байр, хоршил, бага найрал дууны дугуйланд I байр тус тус эзлэн алтан медаль;
- **2013 он:** Өвөр монголын соёлын сурталчилгаа тэмдгийн шагнал
 - Шиаман хотноо болсон Бүх улсын арван жилийн сургуулийн урлагийн IV наадамд I байр;
- **2013 он:** Өвөр монголын монгол хятад шинэ оны тоглолт

- “Дорно-2013 онлайн шинэ оны үдэшлэг”-ээс “Үзэгчийн бахархалт” шагнал;
- Австрийн Граз хотноо болсон найрал дууны уралдаанд залуучуудын болон ардын ангилалд тус тус алтан медаль;
- **2016 он:** Бүх улсын арван жилийн сургуулийн урлагийн V наадамд найрал дууны I байр тус тус эзэлжээ.

Өвөр монголын багачуудын найрал дууны бүлгэм нь энэ хугацаанд ӨМӨЗО-ны уран сайхны соёлын хүрээнд аливаа урлагийн үйл ажиллагааны голлох төлөөлөл болж, олон арван тоглолтыг зохион байгуулж, хүүхэд залуусын урлагийн хүмүүжил, гоо сайхны төлөвшилд зохих нөлөөг үзүүлсээр ирсэн юм. Тухайлбал, Ооман хотноо олон улсын XIV хөгжмийн наадмын тоглолт /2010/, Тяньжин хотноо зохиогдсон “Өндөрлөг, дуу мэт” тоглолт /2011/, Бээжингийн дуурь бүжгийн театрт “Бяцхан өвс болон одод орчлон” тоглолт, “Өвөр монголын соёлын өдөрлөг”-т “Хүүхдийн тэнгэрлэг хөгжим” хэмээх тусгай тоглолт /2012/ зэрэг олон жишээ нэрлэж болно.

Эцэст нь бид Өвөр монгол дахь голлох найрал дууны бүлгэмүүдийг он цагийн дарааллаар доор хүснэгтлэн харуулж байна.

Найрал дууны бүлгэм	Байгуулагдсан он сар
“Өвөр монголын утга урлагийн бүлгэм (дууны дугуйлан)”	1946
“Өвөр монголын Радио нэвтрүүлгийн дууны дугуйлан”	1957
“Өвөр монголын Монгол үндэстний залуучуудын найрал дууны бүлгэм”	1987
Өвөр монголын Багшийн их сургуулийн найрал дууны бүлгэм	2000
Өвөр монголын урлагийн сургуулийн “Бай лин” найрал дууны бүлгэм	2002
“Өвөр монголын багачуудын найрал дууны бүлгэм”	2008

Хэлэлцүүлэг

Бид энэхүү судалгаандаа өвөр монголын үе үеийн хөгжим судлаачдын бичиж хэвлүүлсэн ном эмхэтгэл болон өвөр монголын найрал дуутай холбогдох бусад улс орны судлаачдын бүтээл туурвилд үндэслэн, баримт материал цуглуулан ашигласан болно. Бас өвөр монголын ахмад урлагчдаас аман болон бичгийн мэдээг сурвалжлан асууж сураглан өгүүлэлд тусгасан болно.

Найрал дууны урлагийн уран сайхны үйл ажиллагаа нь бүтэц тогтолцооны хувьд бүлгэм, дуучид, удирдаач, уран бүтээл зэргээс бүрдэхийн учир энэхүү өгүүлэлд өвөр монголын найрал дууны бүлгэмийг чухалчлан үзэж, БНХАУ-ын нийгэм цаг үеийн хувьсал өөрчлөлт нь найрал дууны урлагт хэрхэн холбоо хамааралтай байх талаар харгалзан үзэж судалсан болно. Ер нь өвөр монголын найрал дууны урлаг нь бүлгэм төдийгүй нийгэм цаг үе, уран бүтээлчдийн хүчин зүтгэлтэй шууд холбоотой байдгийг судалгаанд хамааруулан тусгасан болно.

Дүгнэлт

Өвөр монголын найрал дууны бүлгэмийн замнал нь БНХАУ-ын тухайн цаг үе, нийгэм соёлын хөгжлийн хүрээнд хөгжихдөө дараах хэд хэдэн үе шатыг дамжсан хэмээн үзлээ. Үүнд: (1937-1945) Японы дайн дуусаж, дотооддоо төр засгаа бэхжүүлэх шаардлагатай байсан үеийн үзэл суртал ухуулгын хэв шинжит урлаг давамгайлж байсан 1946 онд анхны утга урлагийн бүлгэм байгуулагджээ. Тэрээр 1947 оноос хойш ӨМӨЗО чөлөөлөгдөх үеийн төр засгийн бодлогын үр дүнд урлаг соёлын үйл ажиллагаа сэргэн хөгжсөн үе болох ба 1957 онд Өвөр монголын Радио нэвтрүүлгийн дууны дугуйлан байгуулагдаж, найрал дуутай холбоотой олон үйл ажиллагаа өрнүүлж байв.

Харин 1987 онд “Өвөр монголын Монгол үндэстний залуучуудын найрал дууны бүлгэм” байгуулагдсанаар Өвөр монгол оронд найрал дууны урлаг мэргэжлийн түвшинд системтэй хөгжих гараа эхэлсэн юм. Энэ бүлгэмийн амжилт бүтээл нь удирдаач Ц.Ялуунгэрэл, Г.Хүрэл, хөгжмийн зохиолч С.Энхбаяр нартай шууд холбоотой хэмээн үзэж болно.

2008 онд байгуулагдсан багачуудын найрал дууны суурь анги болох “Өвөр монголын багачуудын найрал дууны бүлгэм” нь өвөр монголын засгийн ордны “залуу бага урлагчдыг хүмүүжүүлэх” гэсэн төслийн дор энэ цагийн өвөр монголын урлагийн нэрт төлөөлөгчид болох найрал дууны удирдаач Ц.Ялуунгэрэл, хөгжмийн зохиолч С.Энхбаяр нарын нөр их хүч чармайлтаар үүсэж бий болон, дуучдын урын сан, ур чадварын хувьд жилээс жилд улам бүр чанаржиж, эрчимтэй хөгжиж, өдгөө хүртэл үйл ажиллагаа өрнүүлж байгаа юм.

Ашигласан материал

- Ка Жи Үн., Жан Шан Чүн. 1987. *Өвөр монголын Радио Телевизийн түүх*. Хөх хот.
Мэлчиг, Ж. 2006. “Өвөр монголын урлагийн бүлгэмийн улирал хувьсал.” *Жилийн урлагийн сургууль*. Чан Чүн хот.
Үү Ли Шин. 1998. *Хөгжмийн онолын тухай гарын авлага*. Хөх хот.
Эрдэнэчимэг, Л. 2015. *Монгол гурь дуу 3*. УБ.

Ярилцлага:

- Г.Хүрэлтэй Өвөр монголын залуучуудын найрал дууны бүлгэмийн тухай хийсэн ярилцлага. Хөх хот. 2018. 10. 5.
Д.Цэцэнтархитай Өвөр монголын найрал дууны тухай хийсэн ярилцлага. Хөх хот. 2023.06.03.